



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 10 сарын 27 өдөр

Дугаар 1/326

Сүхбаатар сум

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 "а", Биеийн тамир спортын тухай хуулийн 8.1.1, 8.1.2, 8.1.3, 24.2, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ыг 2.1.4 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 13 дугаар тогтоолоор батлагдсан аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.8 заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сэлэнгэ аймгийн Мандал сумын иргэн Г.Эрхэмбаяр нь 2021 оны 11 дүгээр сарын 11-13-ны өдрүүдэд Америкийн Нэгдсэн Улсын Невада мужид зохион байгуулагдах "World Master 2021 IBJJF jiu-jitsu Championship" мастерын дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд оролцох тул байр, хоол, замын зардалд дэмжлэг үзүүлсүгэй.

2.Дэмжлэгт шаардагдах 2.000.000 /хоёр сая/ төгрөгийг аймгийн Засаг даргын нөөцөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /О.Мөнхбаяр/-т зөвшөөрсүгэй.

3.Зардлын тайланг 2021 оны 11 дүгээр сарын 20-ны дотор аймгийн Засаг даргын Тамгын газарт ирүүлэхийг Биеийн тамир, спортын газрын дарга /У.Батмөнх/-д даалгасугай.

ДАРГА

Ш.ОРГИЛ

420910917